



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/409

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дахь заалт, 4.1 дэх хэсэг, Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлын 2026 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 12 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Хэрлэн зусланд 2026 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдах олон улсын III Жемборид аймгаас оролцох багш, хүүхдүүдийн замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ